



**ХЭНТИЙ АЙМГИЙН
НОРОВЛИН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 09 сарын 23 өдөр

Дугаар А/109

Жаргалант

Ажлын хэсэг томилох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийг 66.1 дэх хэсэг, Батлан хамгаалах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.4, Цэргийн албаны тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.3 дахь заалт, Аймгийн Засаг даргын 2025 оны А/509 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.2025 оны хоёрдугаар ээлжийн цэрэг татлагын ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

Ажлын хэсгийн ахлагч Гишүүд	М.Мөнгөнтуяа	ХАА-н тасгийн мэргэжилтэн
	Х.Амарбаясгалан	Баян-Өлзийт багийн засаг дарга
	Г.Оюунчимэг	Жаргалант багийн засаг дарга
	А.Уранчимэг	Ангирт багийн Засаг дарга
	Э.Бат-Орших	Онон багийн Засаг дарга
	Г.Энхзул	ЭМТ-ийн их эмч
	Б.Тунгалагмөрөн	нярав
	Т.Уугантүшиг	жолооч
	Ц.Цэнгэл	жижүүр
	Б.Цолмонболд	жижүүр

2.Цэрэг татлага явагдах өрөө тасалгааг стандартын дагуу тохижуулж, ариутгах, хүн нэг бүрийн нэг удаагийн улавч, хувцасны уут бэлтгэж, гар ариутгалын бодисоор хангаж ажиллахыг ажлын хэсэгт үүрэг болгосугай.

3.Цэргийн албанд зарлан дуудах мэдэгдлийг нэрсийн жагсаалтад орсон цэргийн албанд татагдагч бүрд хүргүүлэн 2025 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн 10:00 цагт сумын Цэрэг татлагын байранд бэлэн байлгах, тэдний бичиг баримтыг бүрдүүлэх ажлыг багийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

4.Цэргийн албанд татагдагчийн цусны бүлэг тогтоох, хэвлийн чанд авиа оношилгоо, шээсний шинжилгээг урьдчилан 2025 оны 10 дугаар сарын 7-ны өдрөөс 09-ний өдөр хүртэл зохион байгуулан ажиллахыг ажлын хэсгийн ахлагч (М.Мөнгөнтуяа)-д даалгасугай.

D:bichig hereg /zahiramj-2025

232501262

2.

5.Цэрэг татлагын товчооны бүрэлдэхүүнийг ажиллах нөхцөл, хоол хүнсээр хангах, цэргийн албанаас халагдан ирж буй дайчдыг угтан авч, тэднийг ажлын байранд зуучлах, цэргийн албанд татагдагчдыг үдэж мордуулах ажлыг сахилга, зохион байгуулалтын өндөр хэмжээнд зохион байгуулахыг ажлын хэсэгт үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ө.ДАВААЖАРГАЛ